

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

## ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 3 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

### “Өндөрхаан инвест” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Өндөрхаан инвест” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2009 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ